



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/213

Мандалговь

Комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сумын эрүүл мэндийн төвд нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: О.Уранзаяа (НБМэргэжилтэн),

Нарийн бичгийн дарга: Н.Саранзаяа (Сангийн ня-бо)

Гишүүд: Б.Оюумаа (ЭМТөвийн дарга)

Г.Отгонгонгор (ЭМТөвийн ня-бо)

2. Гэрээнд заасан тоног төхөөрөмж техникийн үзүүлэлт шаардлага хангаж байгаа эсэхийг нягтлан шалгаж, баримтжуулж хүлээж авахыг комиссын дарга, гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ